



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/676

Булган сум

“Амжилтын гараа хөтөлбөр”-ийг  
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт үйл ажиллагааны хөтөлбөр”, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX хуралдааны IX/76 дугаар тогтоолоор баталсан “Амжилтын гараа хөтөлбөр”, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Амжилтын гараа хөтөлбөр”-т заасан бага боловсролын багш нарын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хөтөлбөрийг танилцуулах сурталчлах ажлыг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Боловсролын газрын дарга (Ц.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

3. Сургалтад зарцуулагдах 5,760,400 (таван сая долоон зуун жаран мянга дөрвөн зуу) төгрөгийг “Амжилтын гараа хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010943

Аймгийн Засаг даргын 2025 оны  
10 дугаар сарын 10-ны өдрийн  
1676 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



## “АМЖИЛТЫН ГАРАА ХӨТӨЛБӨР”-ИЙН НЭЭЛТИЙН УДИРДАМЖ

### 1. Удирдамжийн зорилго:

Булган аймгийн бага боловсролын чанарыг сайжруулах, сурагч бүрийн хөгжлийг дэмжих, тэгш боломжийг хангах, орчин үеийн боловсролын үнэт зүйлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн “Амжилтын гараа хөтөлбөр”-ийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдамж, зохион байгуулалтын нэгдсэн чиглэлийг тодорхойлох.

### 2. Хамрах хүрээ:

- Урд бүс Дархан хан бүс, Чин толгой бүс, Булган сумын 2,3 дугаар сургууль
- Хойд бүс Уран тогоо, Сэлэнгэ бүс, Булган сумын 1 дүгээр сургууль
- Булган аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын багш, сургуулийн удирдлага, боловсролын байгууллагууд болон орон нутгийн боловсролын салбарын арга зүйч нар хамаарна.

### 3. Зохион байгуулагдах газар, хугацаа:

Урд бүс Хишиг-Өндөр сум 2025 оны 10 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд,  
хойд бүс Сайхан сум 2025 оны 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд

### 4. Удирдамжийн дагуу танилцуулагдах ажлын үндсэн чиглэл:

#### 1. Багшийн хөгжил ба арга зүйн дэмжлэг

- Бага боловсролын багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих нөхцөлийг бүрдүүлэх;
- Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, цахим контент, кейс судалгаа, туршлагын уулзалтыг зохион байгуулах;
- Багш нарын идэвх, бүтээлч байдлыг дэмжих зорилгоор бүсийн болон аймгийн уралдаан, зөвлөгөөн, арга зүйчдийн нэгдлүүдийг идэвхжүүлэх.

#### 2. Сургалтын орчны шинэчлэл

- Бага боловсролын сургалтын орчныг аюулгүй, хүртээмжтэй, технологид суурилсан байдлаар шинэчлэх;
- Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг багш, сурагчдын хэрэгцээнд нийцүүлэн хангах;
- Цахим платформ, мэдээллийн технологийн кабинет бий болгох замаар дижитал сургалтын соёлыг төлөвшүүлэх.

#### 3. Суралцахуйн амжилтыг ахиулах

- Сурагчдын унших, бичих, тооцоолох суурь чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, хичээлээс гадуурх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Суралцагчдын амжилтыг үнэлэх, хянах, ахиц дүгнэх нэгдсэн системийг боловсронгуй болгох;
- Масс олимпиад, уралдаан, нөлөөллийн арга хэмжээгээр дамжуулан сурагчдын сурах сонирхлыг нэмэгдүүлэх.

#### 4. Гэр бүл, сургууль, олон нийтийн хамтын ажиллагаа

- Эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг бэхжүүлэх
- Сургуулийн удирдлага, багш, гэр бүл, олон нийт хоорондын харилцаа, хамтын ажиллагааг тогтмолжуулах;
- Хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжилд чиглэсэн хамтарсан арга хэмжээг хэрэгжүүлэх.

#### 5.Хэрэгжилтийг удирдах, хянах:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн Боловсролын газар удирдан зохион байгуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.
- Сургуулиуд жил бүрийн хичээлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан “Амжилтын гараа хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн жилийн төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийн тайланг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд багш, эцэг эх асран хамгаалагч, сурагчдын санал бодол, үр дүнгийн судалгааг тогтмол авч үнэлгээнд тусгана.


#### 6.Үр дүн:

- ✓ Бага боловсролын унших, бичих, тооцоолох чадварын түвшин 70 хувьд хүрч, суурь чадварын ахиц мэдэгдэхүйц нэмэгдэнэ;
- ✓ Багшийн мэргэжлийн ур чадвар дээшилж, инновацлаг арга зүй нэвтэрнэ;
- ✓ Сургалтын орчин сайжирч, хүүхэд бүрийн хөгжилд эерэг дэмжлэгтэй орчин бүрдэнэ;
- ✓ Олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа боловсролын чанарын үндсэн баталгаа болж төлөвшинө.

#### 7.Хэрэгжүүлэх хугацаа:

2025-2028 онд 3 жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2025 оны  
10 дугаар сарын 14-ны/ний өдрийн  
11076 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**“АМЖИЛТЫН ГАРАА ХӨТӨЛБӨР”-ийн нээлтийн арга хэмжээний төсөв**

д/д	Зардлын нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Очих сум
1	2	3	4	5	6
1	Цайны зардал	121	8,0*4	2.904,400	Хишиг-Өндөр
2	Цайны зардал	119	8,0*4	2.856,000	Сайхан
	Нийт			5.760.400	